

**УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

2026 он

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Нэг.Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна”, Арван зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж тус тус заасан.

Монгол Улс 1992 онд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын суурь конвенцод нэгдэн орж, энэхүү конвенцыг хэрэгжүүлэх Парисын хэлэлцээрийг 2016 онд Улсын Их Хурлаар соёрхон баталж, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авах арга хэмжээг эрчимжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадвараа сайжруулах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад хувь нэмэр оруулах үүрэг хүлээсэн.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт “6.4.Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулна” гэсэн зорилт дэвшүүлж, 2021-2030 (I үе шат) онд, барилга, тээвэр, аж үйлдвэр, хог хаягдлын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлнэ, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, тэсвэрлэх чадавхыг бэхжүүлж, үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулна, 2031-2040 (II үе шат) онд уур амьсгалын өөрчлөлтийн шинэ хэлэлцээрийн хүрээнд хүлэмжийн хийн үндэсний ялгарлыг бууруулж, нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлнэ, 2041-2050 (III үе шат) онд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээг хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарал ба шингээлтийн зөрүүг тэглэнэ гэж тусгасан байдаг.

“Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан үндсэн чиглэлийн 83-т 1.9.Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийг боловсруулахаар тусгасан.

Дээрх хөгжлийн бодлогод туссан арга хэмжээг хэрэгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь анхдагч хууль хэлбэрээр боловсруулсан байна. Хуулийн төсөл нь иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад шинээр болон өмнө гүйцэтгэж байсан үүрэгт шинээр нэмэгдсэн, эсхүл хасагдсан чиг үүргийн хүрээнд үнэлгээг хийнэ.

Хуулийн төсөл нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, түүнд дасан зохицох болон даван туулах, хүлэмжийн хийн тэнцлийг хангахад чиглэсэн байгаль орчин, эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг хангах, карбон зах зээлийг бүрдүүлэх, уур амьсгалын санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой бүртгэл, мэдээллийн сан, тайлагналын нэгдсэн тогтолцоог бий болгоход чиглэсэн харилцааг зохицуулсан байна.

Аргачлалд заасны дагуу хуулийн төслийн зохицуулалтаар шинээр орж байгаа чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцсон болно. Хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлан чиглэгдэх болно.

Хоёр. Иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардлыг тооцсон байдал

Зардал тооцсон субъект:

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход дор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан болно:

- Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

“Аргачлал”-ын 1.5-д заасны дагуу дараахь 3 этгээдтэй холбогдон гарах зардлыг тооцов.

1. Иргэнд үүсэх зардал;
2. Хуулийн этгээдийн зардал;
3. Төрийн байгууллагын зардал.

1. Иргэнд үүсэх зардал


Хуулийн төслийн хүрээнд аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй хувь хүнийг багтаан үзсэн болно.

Дүгнэлт: Хуулийн төслөөр иргэний хувьд нэмж гүйцэтгэх үүрэг үүсэхгүй тул иргэнд шууд үүсэх зардал байхгүй болно.

2. Хуулийн этгээдийн зардал:

Дэлхийн хэмжээнд эрчим хүч, хөдөө аж ахуй, тээвэр, аж үйлдвэрийн салбар нүүрстөрөгч ялгаруулалтын хэмжээ өндөр байдаг бол Монгол Улсын хувьд нийт нүүрстөрөгч ялгарлын 90 хувиас дээш хэмжээг эрчим хүч, хөдөө аж ахуй салбар ялгаруулж байна. Эрчим хүчний салбарын хувьд эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглаж буй хатуу түлшнээс үүдэлтэй ялгарал зонхилдог бол хөдөө аж ахуйн салбарын хувьд мал, амьтны ялгадаснаас ялгарч буй метан зонхилдог байна.

Зураг1. Дэлхийн нүүрстөрөгч ялгаруулалт салбараар, 2023



Эх сурвалж: US Environmental Protection Agency

Монгол Улсын хувьд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн гарах зардал өндөр байдаг бөгөөд эдийн засагт нөлөөлөл үзүүлж байна. Тухайлбал, дундаж температур 1°C-аар урт хугацаанд нэмэгдэх нь манай улсын ДНБ-ий өсөлтийг 7-8 улирлын дараа ойролцоогоор 0.48 хувиар бууруулж, сөрөг нөлөө нь гурван жил хүртэл үргэлжилдэг болохыг харуулж байна. Монголын эдийн засгийн бүтэц бүс нутгаас хамааран ялгаатай байдаг. Жишээлбэл, хангай болон төвийн бүс нутаг хөдөө аж ахуйгаас ихээхэн хамааралтай байдаг бол говийн бүс нутаг нь уул уурхай давамгайлсан эдийн засагтай байдаг. Бүс нутгийн хувьд судалсан үр дүнгээс үзвэл хөдөө аж ахуйн салбар давамгайлсан Хангайн бүс нутаг температурын хэлбэлзэлд онцгой мэдрэмтгий болохыг харуулж байна. Суурь тооцоогоор Хангайн бүс нутгийн

дундаж температур 1°C-ээр нэмэгдэх нь бүс нутгийн эдийн засгийн өсөлтийг 0.7%-иар нэмэгдүүлэхтэй холбоотой юм.¹

Температурын өөрчлөлт нь байгалийн гамшгийн давтамж нэмэгдэхэд хүргэдэг бөгөөд энэ нь эдийн засагт ч бас нөлөөлдөг. Үндэсний Статистикийн Хорооны мэдээлснээр, 2000-2017 оны хооронд Монгол Улсад жилд дунджаар 1.1 сая малын хорогдол гарсан бөгөөд гамшгаас үүдэлтэй эдийн засгийн жилийн дундаж зардал 2024 оны байдлаар 75 тэрбум төгрөг болжээ²

Жил ирэх тусам дулаан хангамжийн эрэлт нэмэгдсэнээс гадна дулаан хангамжтай холбоотой шууд зардал 2025 оноос хойш томоохон өөрчлөлтөд орж байна. Өмнө нь Улаанбаатар хотод халаалтын тариф 506 төгрөг, Дархан, Эрдэнэ, Чойбалсан зэрэг бүс нутгийн хотуудад 648 төгрөг байсан. Эдгээрийг Улаанбаатар хотод 936 төгрөг, бүс нутгийн хотуудад 1199 төгрөг болгон 85%-иар нэмэгдүүлсэн байна. Эдгээр арга хэмжээ нь нийлүүлэлтийн зардлыг үйлдвэрлэлийн өртгөөс хамаагүй бага байлгадаг засгийн газрын зохицуулалттай тарифын дараа хийгдсэн. Энэхүү бодлогын шийдвэр нь эрчим хүчний салбарын үр ашгийг дээшлүүлэхэд зайлшгүй шаардлагатай боловч Улаанбаатар хотын хамгийн эмзэг бүлгийн хүн амыг уур амьсгалын өөрчлөлтийн улмаас цаашид эрсдэлд оруулахад хүргэж байгаа юм.

Хүснэгт 1. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой зардал, Монгол Улс

Үзүүлэлт	Нэгж	Хамрах хугацаа	Дундаж
Малын хорогдол	сая толгой	2000-2017	1.17
Ойн түймэр	сая га	2000-2017	2.9
Ахуйн гал түймэр	нэгж	2000-2017	2861
Гамшгаас үүдсэн нас баралт	хүн	2000-2024	206
Гамшгаас үүдэлтэй дундаж хохирол	тэрбум төгрөг	2000-2024	75

Хуулийн төсөлд ногоон санхүүжилт, карбон зах зээлтэй холбоотой бүлэгт уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хүлэмжийн хийг бууруулахтай үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой төсөл, арга хэмжээний хүрээнд иргэн, хуулийн этгээдэд ногоон санхүүгийн хэрэгсэл, хөшүүргийн хүрээнд төрөөс дэмжлэг үзүүлэх, хүлэмжийн хийн ялгарлыг тооцуулж арилжаалах замаар нэмэлт орлого, хөрөнгө оруулалт татах боломж бүрдэхээр байна.

¹ Уур амьсгалын өөрчлөлтийн нийгэм, эдийн засагт үзүүлж болох нөлөө, учирч болох эрсдэл: Монгол Улсын жишээ, Ананд ба Хосбаяр, 2022 он

² Үндэсний Статистикийн Хороо, 2025 он

Үйл ажиллагаатай холбоотой төсөл арга хэмжээний онцлогоос хамаарч үйл ажиллагаандаа олон улсын стандартын шаардлагыг хангуулахтай холбоотой тодорхой хэмжээний зардал гаргах боловч тухайн хуулийн этгээдийн өрсөлдөх чадвар нэмэгдэж, нэмэлт санхүүжилт, орлого олох боломж бүрдэх тул хуулийн этгээдэд эерэг нөлөөтэй байна.

Түүнчлэн хуулийн төсөл батлагдсанаар уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах үйл ажиллагааны бодлого, зохицуулалт төрийн байгууллагын эрх үүрэг тодорхой болж, мэдээллийн ил тод байдал хангагдах тул хуулийн этгээдийн үйл ажиллагаанд дэмжлэг болно.

Дүгнэлт: Хуулийн төслөөр хуулийн этгээдийн хувьд шууд үүсэх зардал байхгүй, харин хуулийн этгээдүүдэд зардал талаасаа илүү таатай орчин бүрдэж байна.

3. Төрийн байгууллагын зардал:

Хуулийн төслийн хүрээнд одоогийн тогтолцооны хүрээнд үйл ажиллагаа явуулах боломжтой бөгөөд тухайн төрийн байгууллагад уур амьсгалын өөрчлөлтийн асуудал хариуцсан бүтцийн нэгж, албан тушаалын орон тоог шинээр бий болгох зардал үүсэх боловч батлагдсан төсвийн хүрээнд шийдвэрлэгдэх бүрэн боломжтой гэж үзэж байна.

Улсын Их Хурлын бүрэн эрх: Хуулийн төсөлд УИХ-аас уур амьсгалын өөрчлөлтийн хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичиг батлах, хяналт тавих, хуулийн хэрэгжилтийг төсөв, батлах, төсөв батлах, хуулийн тогтоомжийг хэрэгжилт, тайланг хэлэлцэх хяналт тавих бүрэн эрхийг хэрэгжүүлэх тул шинээр орон тоо нэмэх, бүтэц өөрчлөх шаардлагагүй тул төсөвт ямар нэгэн зардал нэмэгдэхээргүй байна.

Засгийн газрын бүрэн эрх: Уур амьсгалын өөрчлөлтийн талаар үндэсний түвшний урт болон дунд хугацааны бодлого, стратеги, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, салбар хоорондын уялдааг хангах, холбох эрх зүйн хэм хэмжээний актыг батлах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх тул шинээр орон тоо нэмэх, бүтэц өөрчлөх шаардлагагүй тул төсөвт ямар нэгэн зардал нэмэгдэхээргүй байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх: Хуулийн төсөлд туссан чиг үүргүүд нь олон улсын гэрээгээр хүлээн үүрэг, хэм хэмжээний актын хүрээнд зохицуулагдаж байгаа асуудлыг тодорхой болгосон.

Хуулийн төсөл батлагдсанаар чиг үүрэг хуульд тусгагдаж, үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн орчин бүрдэх бөгөөд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны батлагдсан орон тооныхоо хүрээнд чиг үүргийнхээ хүрээнд хэрэгжилтийг хангах боломжтой тул улсын төсөвт нэмэлт зардал шаардагдахгүй.

Түүнчлэн хуулийн төсөл батлагдсанаар олон улсын байгууллага болон хөгжлийн санхүүжилтийн хүрээнд хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдээр дамжуулан тодорхой чиглэлээр техникийн болон санхүүгийн дэмжлэг авах замаар шийдвэрлэх боломжтой.

Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх: Одоогийн бүтэц зохион байгуулалтын хүрээнд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой хэрэгжүүлэх арга хэмжээг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгах, салбар дундын уялдааг хангах, макро эдийн засгийн бодлого чиглэлтэй уялдуулах ажиллах тул улсын төсөвт нэмэлт зардал шаардагдахгүй.

Салбарын болон бусад төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх: Төрийн захиргааны төв байгууллагууд нь салбарын хэмжээнд хэрэгжүүлэх бодлого арга хэмжээг тодорхойлох хэрэгжүүлэхэд уур амьсгалын өөрчлөлтийн арга хэмжээтэй уялдуулах, мэдээл тайлан гаргах асуудлыг хуульчилж өгсөн бөгөөд төсөвт зардал үүсэхгүй байна.

Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал болон Аймаг, нийслэлийн засаг даргын бүрэн эрх: Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх орон нутгийн түвшний арга хэмжээний хэрэгжилтийг хангахтай холбоотой эрх үүргийг тодорхойлж өгсөн тул нэмэлт зардал гаргахгүй.

Бусад асуудлаар: Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой салбар дундын асуудлаар Засгийн газрын түвшинд хороо, комисс, салбарын асуудлаар оролцогч талуудтай ажлын хэсэг байгуулах замаар шийдвэрлэх боломжтой. Түүнчлэн Хүлэмжийн хийн тооллого, уур амьсгалын өөрчлөлтийн тайлан судалгааг батлагдсан төсвийн хүрээнд тухай бүр шийдвэрлэх боломжтой байна.

Дүгнэлт: Хуулийн төслөөр төрийн байгууллагуудын хувьд шинээр орон тоо, бүтцийн нэгж байгуулагдах боловч, төсөвт ямар нэгэн зардал нэмэгдэхгүй түүнчлэн гадаад хамтын ажиллагааны хүрээнд шийдвэрлэх боломжтой байна.

Гурав. Дүгнэлт

Зардлын тооцооны судалгааны үр дүнд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөлтэй холбогдон иргэн, хуулийн этгээд, холбогдох төрийн байгууллагад нэмэлт зардал гарахгүй, төсөвт дарамт учрахгүй нь тогтоогдов.

Харин уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хүлэмжийг хийг бууруулахад чиглэсэн төсөл арга хэмжээ хэрэгжүүлж буй иргэн хуулийн этгээдэд нэмэлт санхүүгийн эх үүсвэр татах боломж нэмэгдэж, инновац, дэвшилтэд технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх давуу тал үүснэ.

--oOo--